



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2016 оны 8 дугаар сар


Ерөнхий тойм: Оны эхний 8 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 10.9%-иар буюу 631.6 сая ам.доллараар буурч 5166.8 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 7.9%-иар буюу 258.2 сая ам.доллараар, импорт 14.7%-иар буюу 373.3 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 819.9 сая ам.доллараар давж гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 115.1 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 8 сараар			Өөрчлөлт			
	2013	2014	2015	2014/2013		2015/2014		2014	2015	2016	2015/2014		2016/2015	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,627	11,011	8,467	384	3.6%	(2,544)	-23.1%	7,176	5,798	5,167	(1,377)	-19.2%	(632)	-10.9%
Экспорт	4,269	5,774	4,669	1505	35.3%	(1,105)	-19.1%	3,576	3,252	2,993	(325)	-9.1%	(258.2)	-7.9%
Импорт	6,358	5,237	3,797	(1,121)	-17.6%	(1,440)	-27.5%	3,599	2,547	2,173	(1,052)	-29.2%	(373.3)	-14.7%
Тэнцэл	(2,089)	538	872	2,626		335	62.2%	(23)	705	820	728		115.1	16.3%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид нөлөөлдөг суурь хүчин зүйлүүдийн нэг юм. Валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2016 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 801.5 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 59.3 сая ам.доллараар буурсан байна.

Дүрслэл 1. Валютын төлбөртэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Дүрслэл 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 60.5% буюу 3123.7 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 11.9% буюу 612.6 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 15.0%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 16.5%-иар тус тус буурсан байна.

Дүрслэл 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Хүснэгт 2. Худалдааны нөхцөлийн индекс /2012 оны 12 сар суурьтай/

Үнийн индексийн төрөл*	2015.8 сар	2016.7 сар	2016.8 сар	Жил Δ	Сар Δ
Экспорт	0.82	0.69	0.68	-17%	-1%
Зэсийн баяж мал	0.42	0.30	0.30	-30%	-13%
Чулуун нүүрс	0.44	0.38	0.38	-13%	0.3%
Ямааны угаасан ноолуур	0.37	0.33	0.31	-16%	-4.9%
Импорт	0.63	0.56	0.59	-7%	5%
Хэрэглээний бараа	0.79	0.77	0.74	-6%	-3%
Хөрөнгө оруулалтын бараа	0.55	0.49	0.56	1%	13%
Нефтийн бүтээгдэхүүн	0.63	0.50	0.50	-21%	0%
Худалдааны нөхцөл	1.29	1.22	1.15	-11%	-6%

* Индексийн өөрчлөлтөд голлох хувь нэмэр оруулсан бараагаар задлав.

Гадаад худалдааны нөхцөлийн индекс тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 11.0%-иар, өмнөх сараас 5.9%-иар буурч 1.149-д хүрлээ. Тайлант сард хөрөнгө оруулалтын барааны импортын үнэ өссөн, зэсийн баяжмалын экспортын үнэ буурснаас худалдааны нөхцөл өмнөх сараас буурсан байна.

Экспорт 2016 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 7.9%-иар буюу 258.2 сая ам.доллараар буурсан. Экспортын бууралтыг ерөнхий ангиллаар задалбал аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын өсөлт нь нийт экспортыг 2.4%-иар өсөхөд нөлөөлсөн ч, уул уурхайн түүхий эдийн экспортын бууралт нь нийт экспортыг 9.1%-иар буурахад нөлөөлжээ. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 2.4 нэгж хувиар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний жин 3.0 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
I. Уул уурхай		3,157	88%		2,818	87%		2,522	84%	(338)	-11%	-9%	(297)	-11%	-9%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	844	1,449	41%	930	1,567	48%	1,088	1,165	39%	118	8%	3%	(403)	-26%	-12%
1.2. Чулуун нүүрс	12,225	588	16%	9,571	401	12%	13,528	417	14%	(187)	-32%	-5%	15	4%	0%
1.3. Боловсруулаагүй нефть	4,441	443	12%	5,193	264	8%	5,438	216	7%	(180)	-41%	-5%	(48)	-18%	-7%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	3,761	289	8%	3,055	150	5%	4,041	156	5%	(139)	-48%	-4%	6	4%	0%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	5,126	214	6%	6,959	263	8%	9,631	390	13%	49	23%	1%	127	48%	4%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	69	76	2%	72	89	3%	88	94	3%	13	17%	0%	5	6%	0%
1.7. Жонош, лейцит, нефелинт	207	47	1%	182	43	1%	163	39	1%	(4)	-9%	0%	(4)	-9%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2	18	1%	3	21	1%	4	17	1%	3	18%	0%	(5)	-22%	0%
1.9. Гянт болдын хүдэр, баяжмал	1	9	0%	1	9	0%	1	6	0%	(0)	-5%	0%	(3)	-35%	0%
1.10. Мөнгө /тонн/	32	20	1%	48	10	0%	47	19	1%	(1)	0%	0%	10	100%	0%
1.11. Бусад	18	2	0%	48	1	0%	66	4	0%	(1)	-35%	0%	3	0%	0%
2. Мал аж, ахуй		292	8%		262	8%		234	8%	(29)	-10%	-1%	(29)	-11%	-1%
2.1. Амьд мал, малын мах	1	1	0%	2	6	0%	3	7	0%	5	334%	0%	1	11%	0%
2.2. Арьс, шир	207	25	1%	177	19	1%	110	17	1%	(5)	-21%	0%	(2)	-13%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	5	0%	0	6	0%	0	4	0%	1	17%	0%	(2)	-27%	0%
2.4. Ноолуур	6	251	7%	6	220	7%	6	192	6%	(3)	-12%	-1%	(28)	-13%	-1%
2.5. Ноос, бусад үс, хялгас	6	10	0%	7	11	0%	9	13	0%	1	15%	0%	2	17%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	0	0%	0	1	0%	0	321%	0%	0	80%	0%
3. Газар тариалан		16	0%		21	1%		12	0%	5	32%	0%	(9)	-42%	0%
I. Аж үйлдвэрлэл		110	3%		148	5%		225	8%	38	34%	1%	77	52%	2%
4.1. Хүнс	0	4	0%	2	16	0%	4	22	1%	12	329%	0%	6	39%	0%
4.2. Ноолууран эдлэл	0	14	0%	0	15	0%	0	14	0%	1	7%	0%	(1)	-7%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	1	5	0%	0	6	0%	1	7	0%	1	22%	0%	2	29%	0%
4.4. Уул уурхай	11	24	1%	28	57	2%	19	49	2%	33	139%	1%	(8)	-14%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	3	0%	0	2	0%	0	1	0%	(2)	-51%	0%	(1)	-58%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эданги	2	55	2%	1	48	1%	1	127	4%	(7)	-12%	0%	79	163%	2%
4.7. Бусад	166	5	0%	128	4	0%	169	5	0%	(1)	-20%	0%	1	15%	0%
5. Бусад		2	0%		2	0%		1	0%	0	15%	0%	(1)	-63%	0%
Нийт дүн		3,576		3,252			2,993			(325)	-9%		(258.2)	-7.9%	

%² - Нийт өсөлтөө оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2016 он

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	461.5	-155%	(758.4)	255%	(296.9)	-11%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	169.0	-42%	(571.7)	142%	(402.7)	-26%
1.2. Чулуун нүүрс	121.9		(106.4)		15.5	4%
1.3. Боловсруулаагүй нефть	9.7	-20%	(57.6)	120%	(47.9)	-18%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	38.0		(32.4)		5.6	4%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	108.2	85%	18.6	15%	126.9	48%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	16.6	327%	(11.5)	-227%	5.1	6%
1.7. Жонош, лейцит, нефелинт	(4.5)	114%	0.6	-14%	(4.0)	-9%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	4.0	-83%	(8.8)	183%	(4.8)	-22%
1.9. Гянт болдын хүдэр, баяжмал	(2.2)	70%	(0.9)	30%	(3.1)	-35%
1.10. Мөнгө /тонн/	(0.4)	-4%	10.0	104%	9.6	100%
1.11. Бусад	1.2	40%	1.8	60%	3.0	0%
2. Мал аж, ахуй	(10.3)	36%	(18.5)	64%	(28.8)	-11%
2.2. Арьс, шир	(10.2)	412%	7.7	-312%	(2.5)	-13%
2.4. Ноолуур	(5.1)	18%	(22.6)	82%	(27.7)	-13%
3. Газар тариалан	(2.5)	28%	(6.4)	72%	(8.9)	-42%
4. Аж үйлдвэрлэл	(8.3)	-11%	85.8	111%	77.5	52%
5. Бусад	(0.2)	14%	(1.0)	86%	(1.1)	-63%
Нийт дүн	440.2		(698.5)		(258.2)	-8%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Дүрслэл 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2016 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 440.2 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 698.5 сая ам.доллараар буурсан байна. Бүлэг тус бүрээр авч үзвэл уул уурхайн түүхий эдийн экспорт тоо хэмжээний өсөлтөөс шалтгаалан 461.5 сая ам.доллараар өссөн хэдий ч үнийн бууралтаас шалтгаалж 758.4 сая ам.доллараар буурснаас нийт дүнгээр 296.9 сая ам.доллараар буурлаа. МАА-н түүхий эдийн экспорт үнэ, тоо хэмжээ зэрэг буурснаас шалтгаалж 28.8 сая ам.доллараар буурсан байна. Харин машин, тоног төхөөрөмжийн экспортын өсөлтөөс голчлон шалтгаалж аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт 52%-иар буюу 77.5 сая ам.доллараар өсчээ.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2016 оны 8 дугаар сард 1,339 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 20%-иар өссөн бол өнгөрсөн сараас 1.3%-иар буурчээ. А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ тайлант сард харгалзан 4,752, 61 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 7%-иар буурч, төмрийн хүдэр 8%-иар өссөн бол өнгөрсөн сартай харьцуулахад зэс 2%-иар буурч, төмрийн хүдэр 6%-иар өссөн байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 8 дугаар сард 32 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 4%-иар буурсан бол өмнөх сараас 1%-иар өссөн.

Импорт 2016 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 14.7%-иар буюу 373.3 сая ам.доллараар буурсан. Импортын бууралтыг ерөнхий ангиллаар задалвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 9%-ийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 7%-ийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 6 нэгж хувиар өссөн бол нефтийн бүтээгдэхүүний жин 5 нэгж хувиар буурчээ.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2014			2015			2016			Δ (2015/2014)			Δ (2016/2015)					
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²			
Хэрэглээний бүтээгдэхүүн		919	26%		732	29%		764	35%	(187)	-20%	-5%	32	4%	1%			
Түргэн эдэлгээтэй	540	487	14%	487	410	16%	498	398	18%	(76)	-16%	-2%	(12)	-3%	0%			
Хүнс	256	337	9%	239	280	1%	256	276	13%	(57)	-17%	-2%	(4)	-1%	0%			
Эм, гариа	2	51	1%	2	47	2%	1	56	3%	(4)	-7%	0%	9	19%	0%			
Бусад түргэн эдэлгээтэй бараа	282	99	3%	246	84	3%	241	66	3%	(15)	-16%	0%	(17)	-21%	-1%			
Удаан эдэлгээтэй	113	432	12%	129	322	13%	87	366	17%	(111)	-26%	-3%	44	14%	2%			
Гутал, хувцас, цүнх	26	38	1%	29	31	1%	34	33	2%	(7)	-18%	0%	2	6%	0%			
Гэр ахуйн цах. хэрэгсэл ба төвшлөг	43	86	2%	60	64	3%	16	67	3%	(22)	-26%	-1%	3	4%	0%			
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	1	259	7%	1	183	7%	1	226	10%	(76)	-29%	-2%	43	24%	2%			
Бусад удаан эдэлгээтэй бараа	43	49	1%	40	44	2%	37	40	2%	(6)	-11%	0%	(4)	-9%	0%			
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн		1,522	42%		967	38%		744	34%	(554)	-36%	-15%	(223)	-23%	-9%			
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	17	817	23%	12	492	19%	10	430	20%	(325)	-40%	-9%	(62)	-13%	-2%			
Судлаас бусад төврийн хэрэгсэл, эд анги	1	204	6%	1	81	3%	0	129	6%	(122)	-60%	-3%	48	59%	2%			
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	17	614	17%	11	411	16%	9	301	14%	(203)	-33%	-6%	(110)	-27%	-4%			
Барилгын материал	2,096	546	15%	1,294	351	14%	537	198	9%	(195)	-36%	-5%	(153)	-44%	-6%			
Хөрөнгө оруулалтын бусад бараа	64	158	4%	50	123	5%	36	116	5%	(35)	-22%	-1%	(8)	-6%	0%			
Аж үйлдвэрлэлийн орц		396	11%		349	14%		350	16%	(47)	-12%	-1%	1	0%	0%			
Хүнсний орц	45	25	1%	32	20	1%	178	47	2%	(5)	-21%	0%	28	143%	1%			
Химийн бүтээгдэхүүн	80	63	2%	87	64	2%	77	54	2%	1	1%	0%	(10)	-15%	0%			
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	18	10	0%	11	11	0%	18	12	1%	1	5%	0%	2	15%	0%			
Цахилгаан эрчим хүч	1	81	2%	1	85	3%	1	81	4%	4	5%	0%	(3)	-4%	0%			
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	0	0%	0	1	0%	1	1	0%	1	148%	0%	0	47%	0%			
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалт ат	606	217	6%	549	169	7%	508	153	7%	(48)	-22%	-1%	(16)	-9%	-1%			
Нефтийн бүтээгдэхүүн		714	752	21%		745	482	19%		635	312	14%	(270)	-36%	-8%	(169)	-35%	-7%
Дизель тунш	421	421	12%	430	260	10%	324	147	7%	(161)	-38%	-4%	(113)	-43%	-4%			
АИ-92, АИ-95	196	214	6%	233	155	6%	215	104	5%	(58)	-27%	-2%	(51)	-33%	-2%			
А-80 болон бусад	96	117	3%	82	67	3%	97	61	3%	(50)	-43%	-1%	(6)	-9%	0%			
Бусад		4	11	0%		14	17	1%		65	3	0%		14	-1%			
Нийт дүн																		
		3,599		2,547		2,173		(1,052)		-29.2%		(373.3)		-14.7%				


%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2016 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	(20.6)		52.8		32.2	4%
Түргэн эдэлгээтэй	6.5	-55%	(18.4)	155%	(11.9)	-3%
Удаан эдэлгээтэй	(27.1)	-62%	71.2	162%	44.1	14%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	(285.6)	128%	62.5	-28%	(223.1)	-23%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	(130.2)	209%	67.9	-109%	(62.3)	-13%
Барилгын материал	(153.2)	100%	0.0	0%	(153.2)	-44%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	(2.1)	28%	(5.4)	72%	(7.6)	-6%
Аж үйлдвэрлэлийн орц	26.8		(25.8)		1.0	0%
Нефтийн бүтээгдэхүүн	(47.7)	28%	(121.6)	72%	(169.3)	-35%
Дизель тунш	(48.2)	43%	(64.5)	57%	(112.6)	-43%
АИ-92, АИ-95	(8.9)	18%	(42.0)	82%	(50.9)	-33%
А-80 болон бусад	9.4	-161%	(15.2)	261%	(5.8)	-9%
Бусад	2.5	-18%	(16.7)	118%	(14.1)	0%
Нийт дүн	(324.5)		(48.8)		(373)	-15%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Дүрслэл 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2016 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр импорт тоо хэмжээний өөрчлөлтөөс голлон шалтгаалж нийт дүнгээр 373 сая ам.доллараар буурчээ.

Бүлэг тус бүрээр авч үзвэл хэрэглээний бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ буурсан хэдий ч үнэ нэмэгдсэнээс шалтгаалан уг бүлгийн импорт 32.2 сая ам.доллараар өсчээ.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 23%-иар буюу 223.1 сая ам.доллараар буурсан нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан.

Харин нефтийн бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ болон үнэ зэрэг буурснаар уг бүлгийн импорт 35%-иар буюу 169.3 сая ам.доллараар буурчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2013 оноос эхлэн тогтмол буурч байна. Хилийн үнэ 2012 оны 12 сард тонн тутамд 1,270.5 ам.доллар байсан бол 2016 оны 8-р сарын байдлаар тонн тутамд 501.6 ам.долларт хүрээд байна.